



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 10 сарын 03 өдөр

Дугаар 411

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө олж авах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 3.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын албан ажлын хэрэгцээнд зориулан 94,500,000.00 (ерэн дөрвөн сая таван зуун мянган) төгрөгт багтаан 4 нэр төрлийн 43 ширхэг үндсэн хөрөнгө (компьютер, түүний дагалдах хэрэгсэл)-ийг худалдан авахыг зөвшөөрч, худалдан авах үндсэн хөрөнгийн техникийн үзүүлэлт, үнийн дээд хязгаарыг хавсралтаар тогтоосугай.

2.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Захиргаа, хууль зүйн хэлтсийн дарга Б.Гаваа, Мэдээлэл, технологийн албаны дарга Н.Цэрэнсамбуу нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгө худалдан авах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэст ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА

0002271

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн
411 дугаар тогтоолын хавсралт

ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ХУДАЛДАН АВАХ ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ТЕХНИКИЙН ҮЗҮҮЛЭЛТ,
ҮНИЙН ДЭЭД ХЯЗГААР

Д/д	Үндсэн хөрөнгийн техникийн үзүүлэлт	Тоо шир хэг	Худалдаж авах хөрөнгийн үнийн дээд хязгаар (төгрөг)	
			Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)
1	Таблет (Microsoft-Surface Pro-12.3" Touch-Screen – Intel Core m3 – 4GB Memory – 128GB Solid State Drive)	9	2,500,000.00	22,500,000.00
2	Компьютер (Dell Inspiron 3277 All in One PC)	25	2,500,000.00	62,500,000.00
3	Принтер (HP MFP M130 FN 3 үйлдэлт)	8	600,000.00	4,800,000.00
4	Хэвлэгч (оффисын канон)	1	4,700,000.00	4,700,000.00
	Нийт дүн			94,500,000.00 (ерэн дөрвөн сая таван зуун мянган)